

ЭМИЙН ТАРХВАР СУДЛАЛ

И. Дүүмаам (Ph.D), Алтанмэлмий ХХК

Эмийн тархвар зүйн судалгааны ерөнхий ойлголт. Эмийн тархвар судлал (Фармакоэпидемиологическое исследование- drug epidemiology) - нь Эмнэл зүйн фармакологи, Тархвар зүйн судлал гэсэн хоёр шинжлэх ухааны зааг дээр гарч ирсэн судалгааны шинэ салбар юм.[1] Эмийн бодис хүний биед орсоноор ямар идэвх үзүүлж байгаа нь таашгүй болохоор энэ талаар нарийвчилсан судалгаа хийх нь тулгамдсан асуудал үнэ цэнэтэй өндөр ач холбогдолтой юм. Уг судалгааны гол чиглэл бол судалгааны загварыг янз бүрийн байдлаар нь ярилцсан явдал бөгөөд харамсалтай нь эдгээр гарах асуудлуудыг сурах бичиг, судалгааны материалуудаас олох тийм амар биш байгаа юм. Эмийн тархварзүй судалгаа нь урьдчилан тооцоолоогүй эмийн сөрөг нөлөөний талаар мэдээлэл авах ач холбогдолтой юм. Эмийн тархвар судлал нь янз бүрийн эмийн бэлдмэлүүдийн дан ганц хэрэгцээг судлах бус, эмийн бэлдмэлүүдийн чанар түүний тун хэмжээ, эмийн хэлбэр, үнийн бодлого зэргээс гадна эмчилгээний стандарт хөтөлбөрийн дагуу хэрэглэх дэг журам зэргийг эмийн эмчилгээний үр дүнтэй нь холбож судладаг цогц шинжлэх ухаан юм. Эмийн тархвар зүйн шинжлэх ухааны тодорхойлолт олон янз байгаа боловч дараахь тодорхойлолтонд гол утга санаа бүрэн нийцэх болно. “Хүн амын дийлэнх олонд хэргэлэгдэж байгаа эмийн хэрэглээний дүнд хийсэн шинжилгээ, түүний нөлөөлөл, эмчилгээний идэвхт чанарт өгсөн үр дүн, ач тусыг судалдаг шинжлэх ухааныг эмийн тархвар судлал гэнэ” гэсэн тодорхойлолтыг Санкт-Петербургийн Анагаах Ухааны Их сургуулийн фармакологи эмнэл зүйн тэнхимээс гаргасан байна.[2] Дараах хоёр шинжлэх ухаанаас эмийн тархвар судлалын ялгаатай талыг авч үзэхийн тул, судлах зүйл түүний зорилгын хувьд товч дурьдах хэрэгтэй боллоо.

Фармакологийн шинжлэх ухаан нь: Хүний бие дахь эмийн бодисын үйлчилгээний идэвхийг судалдаг эмнэл зүйн фармакологийн шинжлэх ухаан юм. Эмийн бодисыг хэрэглэхтэй уялдаж гарсан эерэг ба сөрөг үр дагаврын дүгнэлтүүдийг баталгаажуулан сурталчилах түүнчлэн бусад өөр нөлөөлөл тархалтыг тархвар судлалын аргаар шинжлэн судлах шаардлага гардаг. Тийм учраас фармакологийн эдгээр асуудлуудад хариу өгөхийг тулд тархвар судлалын аргыг хэрхэн яаж хэрэглэж болохыг эмийн тархвар судлалын шинжлэх ухаан судлах юм. Эмийн тархвар зүйн судалгаа нь эмнэл зүйн тохиолдол хяналтын ба когорт судалгааны загваруудад хамаарах судалгааны арга аргачлалуудыг ашигладаг.

Тархвар зүйн шинжлэх ухаан бол нийгмийн эрүүл мэндийн суурь шинжлэх ухаан бөгөөд тархвар зүйн судлагаа нь өвчлөл, түүний өвчлөлийн хөдлөл зүй, тархалт, өсөлт бууралт, өвчний тавилан зэргийг судалдаг шинжлэх ухаан юм. Тархвар судлалын үндсэн суурь дээр үүсч байгаа эмийн тархвар зүйн өвөрмөц судалгааны арга болох эмийн тархвар судалгаа нь эмийн зүй зохистой хэрэглээний талаар нотолгоонд тулгуурласан цогц бодлогыг хэрэгжүүлэх болон хяналт тавих цогц судалгааны арга бөгөөд цаашид амжилттай хэрэгжиж байна.

Эмийн тархвар судалгааны зорилго. Өөрийн өвөрмөц шинж чанартай дараахь зорилтуудыг агуулж байдаг.

1.Фармаконадзор (pharmacovigilance) Эмийн зах зээлд нэвтэрсэн эмийн бодисуудын аюулгүй чанар болон таагүй өөр нөлөөлөлүүдэд тасралтгүй мониторинг хяналт хийж байх хэлбэрийг фармаконадзор гэнэ. Одоогийн практикаас фармаконадзор нь эмийн бодисын таагүй нөлөөлөлүүдийн талаарх мэдээлэлийг төв байгууллагад эрүүл мэндийн мэргэжилтэнүүдээр дамжуулан илэрүүлсэн тухай мэдээлэлийг хүргэх төдий үйл ажиллагааг хамаардаг систем харагдаж байна. Төв байгууллага нь янз бүрийн эх үүсвэрээс гаргаж авсан мэдэллүүдийг нэгтгэн эмийн аюулгүй чанрын үзүүлэлтүүдийг хөндлөнгийн сурталчилгаагаар улам илүү зохион байгуулах шаардлагатай байна.

2.Эмийн хэрэглээний судалгааны дүнг шинжлэх. ДЭМБ-аас 1977 онд “ Нийгмийн хүрээнд, эмийн бодисын, хэрэглээ ба ашиглалт, түгээлт, борлуулалтын талаар анагаах ухааны онцгойлон гаргасан дуу хоолой , нийгэм эдийн засгийн үр дагавар” – ыг яаж судлах тухай тодорхойлолт гарсан байдаг. Эмийн тархвар судлагааны хамгийн гол хэсэг нь эмийн бодисын хэрэглээг судласнаар, эмийн бодисын үйлчилгээний болоод гарал үүслийн зэрэглэлийг тодорхойлох явдал юм. Хүн амын зонхилох хэсэгт хэрэглэгдэж байгаа эмүүд хэрхэн харилцан үйлчилж байгааг талаар хоёр талын ойлголт байдаг боловч ялгааг нь яг бодитоор оноосон шийдвэр одоог хүртэл бага байсаар байна. Эмийн хэрэглээ ба эмийн тархвар судалгаа хийснээр эмийн хэрэглээний талаар дараахь олон талын чиглэлд дүгнэлт гаргах боломжоор хангагдана.

3.Эмийн хэрэглээний бүтэц (дүрслэл) (Паттерн) Тухайн цаг хугацаатай харьцуулсан эмийн зарцуулалт, хэрэглээний чиг хандлага, дүр зураг болон түвшин.

4.Эмийн хэрэглээний чанар. Үндэстэний ба тухайн орноос гаргасан стандарт журам ба эмийн бодит хэрэглээний харьцуулалт юм. Үүнд:

- Эмийн сонголт

- Эмийн үнэ
- Эмийн тун хэмжээ
- Эмийн харилцан үйлчилгээ, сөрөг нөлөө, эмийн үнэ эмчилгээний үр дүнд өвчтөний сэтгэл ханамжтай эсэх зэргийг тооцсон байх

5. Хэрэглээг тодорхойлогч (Детерминант) Хэрэглэгчийн шинж чанар (Жишээ нь: Нийгмийн аж байдал, боловсрол, амьжиргааны түвшин зэрэг үзүүлэлтүүдээс хамаарч эмийн бэлдмэлийн хэрэглээнд гаргаж буй хандлага), Уг эмийн сонгосон эмчийн мэргэшил боловсрол болон эмийн сонгох шийдэлд хүрсэн хүчин зүйлүүд, эмийн шинж чанар (эмчилгээний цар хүрээ ба эмийн бүх төрлийн боломж)

6. Эмийн хэрэглээний үр дүн: Эрүүл мэндэд үзүүлсэн үр дүн (эерэг ба сөрөг нөлөөлөл) ба эдийн засгийн үр дагавар.

Эцсийн эцэст эмийн тархвар судалгааны үндсэн зорилго нь: Хүн ам дахь эмийн зохистой хэрэглээний нотолгоонд тулгуурласан дүгнэлт, хяналт үр дүнгийн сурталчилгаа юм. Эдгээр асуудлуудад эмийн тархвар судалгааны арга аргачлалаар хариулт өгөх болно. Дэлхийн олон орнуудад фармакологийн хяналтын үндэсний төвүүд байгуулагдаж, Швейцарын Женев, Швейцарын Уппсала хотууд дахь ДЭМБ-ын төвүүдтэй олон улсын түвшинд холбогдож эмийн бэлдмэлийн мониторинг хяналтын системийн үйл ажиллагааг хамтарч явуулдаг боловч ёс төдий байна гэж үзэж, орчин үед ДЭМБ-ын хүчээр, эмийн бэлдмэлүүдийн сөрөг нөлөөллийн тухай мэдээлэл харилцан солилцох уг системийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах үүднээс эмийн гаж нөлөөний хяналтын олон улсын програмийн хүрээнд дэлхийн 80 гаруй орны үндэсний төвүүд, ДЭМБ –ын сурталчилгааны төвд нэгдээд одоогийн байдлаар 3,5 сая мэдээлэл цугларсан байна.[3] Эмчилгээ, үйлчилгээнд тавих хяналтын тогтолцоо нь нотолгоонд тулгуурлан шийдвэр гаргахтай нягт уялдаж, хийсэн судалгааны үр дүнд, дүн шинжилгээ хийх замаар хянаж шалгах, эмчилгээ үйлчилгээг сонгох боломжийг олгож байгаа ба хяналт шалгалтад баримталдаг эмчилгээ үйлчилгээний стандарт шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нотолгоонд тулгуурлан боловсрогдсон байх шаардлагатайг ДЭМБ-аас баримталж байна.